



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/172-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитын гүйцэтгэсэн: Пийк Ом Аудит ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: [cheegii9989@gmail.com](mailto:cheegii9989@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БҮХТ	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв



САЙХАН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН  
Э.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.25 № 137А/2023/142-НА-СТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 94.3 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 55,338.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,372.7 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 10,232.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 5.7 хувиар хэмнэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

018020127

## **Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 40,569.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,709,515.4	126,177,581.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		73,855,739.0
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		73,855,739.0
3121	Төгрөг		73,855,739.0
31211	Төрийн сангийн харилцах		73,855,739.0
35	БАРАА МАТЕРИАЛ	41,709,515.4	52,321,842.3
354	Хангамжийн материал	41,709,515.4	52,321,842.3
3542	Аж ахуйн материал	8,744,246.0	15,543,925.0
3546	Хүнсний материал	1,662,920.0	
3547	Бусад хангамжийн материал	31,302,349.4	36,777,917.3
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,335,556,867.0	3,281,736,290.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,335,556,867.0	3,281,736,290.4
392	Биет хөрөнгө	3,315,892,867.0	3,264,104,790.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,196,518,053.0	3,196,518,053.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(151,734,516.3)	(219,172,079.1)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,200,402.0	92,142,034.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,753,023.9)	(22,213,163.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,739,720.5	126,669,587.2
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,500,975.6)	(30,538,223.0)
39214	Бусад үндсэн хөрөнгө	193,592,416.0	193,592,416.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(51,130,408.7)	(73,855,034.8)
39217	Ном	961,200.0	961,200.0
393	Биет бус хөрөнгө	19,664,000.0	17,631,500.0
39301	Програм хангамж	8,130,000.0	8,130,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(650,000.0)	(2,682,500.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,184,000.0	12,184,000.0
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,377,266,382.4	3,407,913,871.7
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		24,292,505.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		24,292,505.0
413	Өглөг		24,292,505.0
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		24,292,505.0
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,377,266,382.4	3,383,621,366.7
51	Засгийн газрын хувь оролцоо	3,377,266,382.4	3,383,621,366.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,184,000.0	12,184,000.0
512	Хуримтлагдсан үр дүн	3,365,082,382.4	3,371,437,366.7
5121	Өмнөх үеийн үр дүн	3,365,082,382.4	(12,184,000.0)
5122	Тайлант үеийн үр дүн		3,383,621,366.7
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,377,266,382.4	3,407,913,871.7

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	908,167,321.8	4,712,719,420.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,293,226.8	3,409,855,220.0
120	Нийтлэг татварын бус орлого	26,293,226.8	3,409,855,220.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		3,145,500.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,145,500.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,920,881.5	3,352,772,506.7
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,372,345.3	53,937,213.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	881,874,095.0	1,302,864,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	708,581,800.0	1,064,225,100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	708,581,800.0	1,064,225,100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,682,000.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,682,000.0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	162,610,295.0	238,639,100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	162,610,295.0	238,639,100.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	955,596,741.9	1,329,098,053.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	955,596,741.9	1,329,098,053.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	925,513,102.9	1,226,212,653.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,978,315.0	735,060,783.0
210101	Үндсэн цалин	388,440,895.0	495,051,318.0
210102	Нэмэгдэл	135,875,720.0	187,627,799.0
210104	Урамшуулал	37,661,700.0	22,844,800.0
210105	Гэрээт ажлын хөлс		29,536,866.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,050,026.0	92,258,398.0
210201	Тэтгэврийн даатгал	34,064,226.0	63,593,652.0
210202	Тэтгэмжийн даатгал	23,314,762.0	6,317,941.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,479,952.0	6,122,025.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,128,586.0	1,484,066.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,062,500.0	14,740,714.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,102,695.0	227,346,405.0
210301	Гэрэл, цахилгаан	3,612,546.0	7,786,935.0
210302	Түлш, халаалт	130,354,806.0	201,161,574.0
210303	Цэвэр, бохир ус	10,135,343.0	18,397,896.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,844,200.0	
210401	Бичиг хэрэг	488,300.0	
210402	Тээвэр, шатахуун	800,000.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,505,900.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,334,600.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ажлын эд зүйлс	2,715,400.0	
2105	Нормативт зардал	1,078,900.0	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	191,500.0	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	887,400.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,508,700.0	2,600,000.0
210604	Урсгал засвар	20,508,700.0	2,600,000.0
2107	Томилолт, зочны зардал	289,400.0	
210702	Дотоод албан томилолт	289,400.0	

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,813,000.0	11,297,100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,165,000.0	3,035,500.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		8,261,600.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,847,866.9	157,649,967.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		27,216,491.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,714,200.0	14,741,400.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,133,666.9	115,692,076.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,083,639.0	102,885,400.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,560,100.0	102,885,400.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,060,100.0	70,665,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.0	32,220,400.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,523,539.0	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,523,539.0	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(47,429,420.1)	3,383,621,366.7
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	95,400.0	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	95,400.0	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(95,400.0)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(47,524,820.1)	3,383,621,366.7

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	881,874,095.0	1,306,009,700.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,145,500.0
120	Нийтлэг татварын бус орлого		3,145,500.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		3,145,500.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,145,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	881,874,095.0	1,302,864,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	708,581,800.0	1,064,225,100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	708,581,800.0	1,064,225,100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,682,000.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,682,000.0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	162,610,295.0	238,639,100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	162,610,295.0	238,639,100.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	853,153,195.0	1,187,498,101.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	853,153,195.0	1,187,498,101.0
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	821,406,636.0	1,086,275,621.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,978,315.0	735,060,783.0
210101	Үндсэн цалин	387,325,700.0	495,051,318.0
210102	Нэмэгдэл	136,990,915.0	187,627,799.0
210104	Урамшуулал	37,661,700.0	22,844,800.0
210105	Гэрээт ажлын хөлс		29,536,866.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,050,026.0	92,258,398.0
210201	Тэтгэврийн даатгал	51,401,688.0	63,593,652.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,679,900.0	6,317,941.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,479,952.0	6,122,025.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,128,586.0	1,484,066.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,359,900.0	14,740,714.0

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,102,695.0	203,053,900.0
210301	Гэрэл, цахилгаан	3,612,546.0	7,786,935.0
210302	Түлш, халаалт	130,354,806.0	176,869,069.0
210303	Цэвэр, бохир ус	10,135,343.0	18,397,896.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,022,100.0	
210401	Бичиг хэрэг	738,300.0	
210402	Тээвэр, шатахуун	800,000.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,255,900.0	
210404	Ном, хэвлэл	193,900.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,334,600.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,699,400.0	
2105	Нормативт зардал	957,200.0	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	191,500.0	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	765,700.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,479,700.0	2,600,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.0	
210604	Урсгал засвар	19,979,700.0	2,600,000.0
2107	Томилолт, зочны зардал	289,400.0	
210702	Дотоод албан томилолт	289,400.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,813,000.0	11,297,100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,165,000.0	3,035,500.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		8,261,600.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,714,200.0	42,005,440.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		29,612,940.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,714,200.0	12,392,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,746,559.0	101,222,480.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,223,020.0	101,222,480.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,723,020.0	69,002,080.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.0	32,220,400.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,523,539.0	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,523,539.0	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,720,900.0	118,511,599.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,414,800.0	44,655,860.0
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	31,414,800.0	44,655,860.0
	Дотоод эх үүсвэрээр	31,414,800.0	44,655,860.0
223001	Бусад хөрөнгө	31,414,800.0	44,655,860.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(31,414,800.0)	(44,655,860.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(2,693,900.0)	73,855,739.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		73,855,739.0

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			3,412,607,202.6	3,412,607,202.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	12,184,000.0			12,184,000.0
5	Тайлант үеийн үр дүн			(47,524,820.1)	(47,524,820.1)
6	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,134,000.0		3,365,082,382.4	3,377,266,382.4
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(3,377,266,382.4)	(3,377,266,382.4)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
9	Тайлант үеийн үр дүн			3,383,621,366.7	3,383,621,366.7
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,134,000.0		3,371,437,366.7	3,383,621,366.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,306,506,700.0	1,232,153,961.0	74,352,739.0	94.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,306,506,700.0	1,232,153,961.0	74,352,739.0	94.3
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,195,052,200.0	1,130,931,481.0	64,120,719.0	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	790,399,366.0	735,060,783.0	55,338,583.0	93.0
210101	Үндсэн цалин	564,609,200.0	495,051,318.0	69,557,882.0	87.7
210102	Нэмэгдэл	173,408,500.0	187,627,799.0	(14,219,299.0)	108.2
210104	Урамшуулал	22,844,800.0	22,844,800.0		100.0
210105	Гэрээт ажлын хөлс	29,536,866.0	29,536,866.0		100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,128,134.0	92,258,398.0	6,869,736.0	93.1
210201	Тэтгэврийн даатгал	66,977,634.0	63,593,652.0	3,383,982.0	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,996,200.0	6,317,941.0	1,678,259.0	79.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,437,900.0	6,122,025.0	315,875.0	95.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,605,700.0	1,484,066.0	121,634.0	92.4
210205	Эрүүл мэндийн даатгал	16,110,700.0	14,740,714.0	1,369,986.0	91.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,053,900.0	203,053,900.0		100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,252,100.0	7,786,935.0	(534,835.0)	107.4
210302	Түлш, халаалт	183,243,600.0	176,869,069.0	6,374,531.0	96.5
210303	Цэвэр, бохир ус	12,558,200.0	18,397,896.0	(5,839,696.0)	146.5
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	2,600,000.0	2,600,000.0		100.0
210604	Урсгал засвар	2,600,000.0	2,600,000.0		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,297,100.0	11,297,100.0		100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,035,500.0	3,035,500.0		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,261,600.0	8,261,600.0		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,573,700.0	86,661,300.0	1,912,400.0	97.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,181,200.0	74,268,800.0	1,912,400.0	97.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,392,500.0	12,392,500.0		100.0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	111,454,500.0	101,222,480.0	10,232,020.0	90.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	111,454,500.0	101,222,480.0	10,232,020.0	90.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	79,234,100.0	69,002,080.0	10,232,020.0	87.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,220,400.0	32,220,400.0		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,306,009,700.0	1,306,009,700.0		100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,067,370,600.0	1,064,225,100.0	3,145,500.0	99.7
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,067,370,600.0	1,064,225,100.0	3,145,500.0	99.7
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	238,639,100.0	238,639,100.0		100.0
132001	Орон нутгийн төсвөөс	238,639,100.0	238,639,100.0		100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		3,145,500.0	(3,145,500.0)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,145,500.0	(3,145,500.0)	
31	Мөнгө, түүнтэй адилдах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		73,855,739.0	(73,855,739.0)	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	49	49		100.0
6	Удирдах ажилтан	3	3		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	33	33		100.0
8	Үйлчлэх ажилтан	13	13		100.0
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	576	576		100.0
28	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	31	30	1	96.8
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18	16	2	88.9

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь “Боловсролын үйлчилгээг жигд, хүртээмжтэй үзүүлж ёс зүйтэй иргэн төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Танхимын сургалтыг чанартай зохион байгуулах,
- Хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллах,
- Сургалтын таатай орчин бүрдүүлэх,

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,

- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн

захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг'-ийг мөрдөж ирсэн байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын ерөнхий бсловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,647.5 мянган төгрөгөөр буюу 30.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		73,855.7	73,855.7
Авлага			-
Бараа материал	41,709.5	52,321.8	10,612.3
Үндсэн хөрөнгө	3,335,556.9	3,281,736.4	(53,820.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,377,266.4</b>	<b>3,407,913.9</b>	<b>30,647.5</b>
Өр төлбөр		24,292.5	24,292.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,377,266.4	3,383,621.4	6,355.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,377,266.4</b>	<b>3,407,913.9</b>	<b>30,647.5</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 73,855.7 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 52,321.8 мянган төгрөг болж 10,612.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 89,126.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 12,227.6 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, сургалтын материал зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй авч үйл ажиллагаанд 90,742.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,568,325.8 мянган төгрөг болж 61,871.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 44,655.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авч, БШУЯ-наас 17,215.6

мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Тайлант онд 24,292.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн нь халаалтын үнэ нэмэгдсэн боловч төсвийг урьд оны гүйцэтгэлийг үндэслэж санхүүжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,383,621.4 мянган төгрөг болж 6,355.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,170,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 263,639.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,433,639.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас тэтгэвэр тэтгэмж, ахмадын сан зэрэгт тусгагдсан - 282,202.0 мянган төгрөгийн зардлыг бууруулж, төрийн үйлчилгээний ажилчдын цалин, нийгмийн даатгалын зардлыг 34,304.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 887,798.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 297,943.2 мянган төгрөгийг нийт 1,185,741.2 мянган төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

2022 оны 5 дугаар сард орон нутгийн төсвөөс төрийн үйлчилгээний ажилчдын цалин улсын төсвөөс санхүүжигдэхээр болж 11 дүгээр сард хийсэн төсвийн зохицуулалтаар цалингийн зардлыг 59,304.0 мянган төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 179,572.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 1,067,370.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 238,639.1 мянган төгрөг нийт 1,306,009.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,067,370.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 238,639.1 мянган төгрөг, нийт 1,306,009.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,232,153.9 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 55,338.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,372.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн 1,912.4 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 10,232.0 мянган төгрөгийг тус тус хэмнэж 73,855.7 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасанатай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,304.7	3,304.3	0.4	100.0
		2	80312- Сургалт семинар	1,652.3	1,652.3	-	100.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,800.4	3,800.4	-	100.0
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	79,234.1	69,002.1	10,232.0	87.1
		5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	37,465.0	35,553.0	1,912.0	94.9
		6	81823- Боловсролын багшийн сургалт	7,435.5	7,435.5	-	100.0
		7	81834- Боловсролын стандарт сургалт	771,294.7	709,658.4	61,636.3	92.0
		8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	160,038.4	160,038.4	-	100.0
		9	83603-Сурах бичгийн түрээс	3,075.5	3,035.5	40.0	98.7
		10	80111- Төрийн эмчийн барилгын тогтмол зардал	205,653.9	205,653.9	-	100.0
		11	80112- Нийтлэг үйлчилгээ	32,985.2	32,985.2	-	100.0
		12	120010-Төсөвт байгууллагын өөрийн орлого	70.0	35.0	35.0	50.0
Нийт				1,306,009.6	1,232,153.9	73,855.7	94.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100130915407 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн зардлыг тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөж, батлуулан өр төлбөр үүсгэхгүй ажиллахтай холбосотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Пийк Ом Аудит" ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 7 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 955,596.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,555.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 55,338.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,372.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн 1,912.4 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 10,232.0 мянган төгрөгийг тус тус хэмнэж 73,855.7 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 02-ны 195 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 88,997.2 мянган төгрөгийн, 723.3 мянган төгрөгийн зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар өгсөн 2 зөвлөмжийг 100.0 хувиар хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	89,720.5	2	89,720.5	100.0
Нийт дүн	2	89,720.5	2	89,720.5	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Сайхан сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцоолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан "Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан" гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй юм. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус сургуулийн нягтлан бодогч Д.Гэрэлтуяагийн ажлыг улирал бүр дүгнэж, ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 30.0-45.0 хувиар тооцож олгосон боловч Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 1/643 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "**Зөрчилгүй**" дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,595.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*", 15.1.3: "*Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.  
Цаашид улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан, хууль, эрх зүйн үндэслэлд нийцээгүй урамшуулал олгохгүй байх нь зүйтэй.
4. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бсдлогын баримт бичиг"-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 2,600.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Халаалтын өр төлбөртэй холбоотой асуудлын талаар

1.1 Илрүүлэлт: Дулааны үнэ нэмэгдсэнийг үл харгалзан урьд оны гүйцэтгэлд суурилж төсөв баталж өгснөөс шалтгаалж 24,292.5 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн нь нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд зардлыг тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж, батлуулан өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгажгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Худалдан авсан бараа материалыг орлого аваагүй	1	2,600.0	1	2,600.0			1	2,600.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,600.0</b>	<b>1</b>	<b>2,600.0</b>			<b>1</b>	<b>2,600.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

